



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫИН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 5/40

Хэрлэн сум

Б.Хуланг хөдөлмөрийн  
гэрээгээр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Коронавируст халдварт (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах тухай хуулийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлагыг хангасан Банзарсүрэнгийн Хуланг Санхүү төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. Б.Хулангийн цалинг Т3-5-1 шатлалтай адилтган тогтоож, үндсэн цалинг 642,388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Хуланд үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ГАНБААТАР